

Хориотой нийтлэл

Мүүс-ийн сэтгүүлчийн 4-р ангийн оюутан Э.Раднаахан

13 настай охиныг 4 залуу хулгайлан 4 өдрийн турш ээлжлэн хүчиндсэн хэрэг энэ онд гарсан. хүчингийн хохирогч охины ар гэр цагдаад гомдол мэдүүлэхээр очсон байх үед тус охиныг цагдаагийн офицер ахин хүчиндсэн жигшүүрт хэрэг энэтхэгт гарчээ. энэтхэг бол хүчингийн хэрэг газар авсан орон. гэтэл өнөөдөр манай улсын хүчингийн гэмт хэрэг энэтхэгийг өөлөх хэмжээнд биш гэдгийг бид мэдээгүй яваа нь харамсалтай.

сонсох төдийд дотор арзайж, сэтгэл эмтрэм энэ мэдээ манай улсад ил болгоогүй ч асар олон бий. 2021 оны байдлаар сүүлийн 3 жилийн хугацаанд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 80% нь 10-29 насны охид, эмэгтэйчүүд, 46.8% нь 8-17 насны охид байсан нь аймшигтай гэх үг амнаас бус нүднээс унахаар мэдээлэл байлаа. харамсалтайн энэ бүхэн ердөө л нүдэнд ил байгаа мэдээлэл. үүнээс далдуур бидний мэдээгүй, төр засгийн ч мэдээгүй асар олон хэрэг чимээгүй тахал мэт оршсоор байна.

2012 он ах дүүсээрээ уулзалдан цагаан сарын баярыг тэмдэглэн найр наадам хийн халамцуу суусан эцэг эх 10 настай охиноо хэн нь үл мэдэх балмад этгээдийн дор чимээгүйхэн уйлж байсныг мэдсэнгүй. ямар их айдас, ямар их шаналал мэдэрсэн бол!!!

2013 он найз нөхдийн хамтаар аялал зугаалгад явахдаа өөрийн төрсөн дүүдээ найдан үлдээсэн охиныг нь шөнө бүр өдөн хоргоож өвөртөө оруулан бузарлаж байсныг нь ээж нь мэдсэнгүй. хувь тавиландаа гутарч, хэдэн удаа үхмээр санагдсан бол!!!

2015 он 9-р ангийн дөнгөж 14 настай охин нь жирэмсэн болсноо ч мэдэхгүй явсаар гэдэс нь дэхь үр нь 5 сар хүрч найзуудтайгаа тоглож байх үед нь гэдэс рүү нь хатгуулан өвдөхөд гэдэс нь дотор маань юм хөдлөөд байна гэж хүүхдийн гэнэн цайлган зангаар гайхан балмагдаж байхад төрсөн үрээ жирэмсэн болсныг эцэг эхийн хэн нь ч мэдээгүй явсаар энэ байдалд ирсэн байлаа. хамгийн жихүүцмээр гэдсэнд нь бойжих тэр ураг хүнтэй явж хормойгоо чирлээ гэж нүүр нүдгүй охиныгоо зодох тэр эхийн төрсөн дүү нь болохыг хэн ч тааж үл мэднэ. хүүхэдтэй болохоор юу болдгийг, гэдсэнд яагаад хүүхэд орсныг, өөрт нь юу тохиолдоод байгааг ойлгож ядах тэр бяцхан охин энэ их шаналлыг яаж тэсэн гарсан бол!!!

нүдэндээ ч итгэмгүй энэ бүхэн үгүйсгэхийг хүсэвч үнэн юм...

ганц энэ охины харуусалт амьдрал эцэг эх нь үр хүүхдээ анхаараагүй явдал бус манай улсад эрэгтэй, эмэгтэй аль ч хүүхэд бэлгийн боловсролыг хангалттай хэмжээнд олгож чадаагүй, сургуулийн орчинд сэтгэл зүйчийг ажиллуулаагүйгээс үүдсэн хэрэг. гагцхүү хүн ямар үед жирэмсэн болдог, сарын тэмдэг яагаад ирэхээ больдог талаар хичээлд нь заасан бол гэдэс нь дэхь ургаа амь орохоос нь өмнө мэдэж, өөрт нь тохиолдож байгаа зүйл байж болохгүй гэдгийг ойлгох байсан. хэрэв сургууль дээр нь очоод бүх үнэнээ хэлэх сэтгэл зүйч байсан бол бяцхан охины ариун цагаан сэтгэлд илүү их сэв суухаас нь өмнө таслан зогсоож чадах байсан биз.

гэтэл өнөөдөр хэрэг хийсэн нь сайхан амьдар ч хохирсон нь ахин хохирол амсдаг тийм нийгэмд бид амьдарч байгааг хэн ч анхааралдаа аваагүй учир нь үүний эсрэг хэн ч зогсоогүй, ийм хэргийг хэн ч илчилж

зүрхэлдэггүй, амьдралынхаа туршид хав дарж байгаад энэ бүхний учир шалтгаан оршино. монгол их орны ирээдүй хойчийг алтан савандаа тээх охид, эмэгтэйчүүд нь бэлгийн дарамтанд өртөж, насаараа шаналан өөрийгөө зүхэн байхад улс орон юу хийв.

монгол улс бүх охид эмэгтэйчүүдээ "хамгаална" гэж олон улсын өмнө амласан, хуулиар ч баталгаажуулсан. гэвч монгол улс нүб-ийн эабхут конвенцод 1980 онд нэгдэж, эмэгтэйчүүдийнхээ эрхийн хэрэгжилтийг баталгаажуулах үүрэг хүлээсэн. улмаар 1990 оны үндсэн хуулиар тэгш байдлыг баталгаажуулж, 2011 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталсан ч өнөөдрийг хүртэл монгол улсад эмэгтэйчүүдийн аж байдалд төдийлөн ахиц дэвшил гарахгүй байгааг дээрх асуудлууд илтгэнэ.

түүнчлэн монгол улс нь жендэрийн тэгш бус байдлын индексээр дэлхийн 189 улсаас 99-т (undp, 2020), дэлхийн эдийн засгийн форумын (2020) жендэрийн зөрүүтэй байдлын тайланд дурдсанаар 2018 онд 58 дугаар байранд байсан бол 2020 онд 21 байраар ухарч, 79-т жагссан нь жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

соёлтой нийгмийн боловсронгуй иргэд хэмээн бид ярьсаар ирэх ч үнэн чанар дээрээ хэн нэгэн хамаатны дүүгээ бэлгийн мөлжлөгт оруулдаг, шинээр оюутан болсон охидыг багш нь зүй бусаар харьцаж бэлгийн дарамт үзүүлдэг, эмэгтэй хүн ажилд орохын тулд хэн нэгэн эрийн таашаалд нийцэх хэрэгтэй гэж шаарддаг тийм л цаг үед бид оршсоор байна. гэтэл үүнийг таслан зогсоохын төлөө хүн бүхний оролцоо чухал байна. бид нийгмээрээ хүчирхийлэл, дарамтыг үл тэвчих соёлыг бий болгох хэрэгтэй байна.

хүний эрхийг ноцтой зөрчсөн ийм төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн хүчтэй нөлөөллийн ажил, сурталчилгаа хийх шаардлага хэдийнээ үүссэн. гэтэл өнөөдөр яагаад үүнийг тоохгүй явсаар өдийг хүрэв.

бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярьж мэдээлэх нь маш хүнд, эмзэг сэдэв төдийгүй сэтгэлийн хүнд шархыг дахин сэдрээдэг учир хохирогчид нийгэм, систем тэднийг элдэв өшөө авалт, учирч болзошгүй хор хөнөөлөөс хамгаалж, тэдний нэхэмжлэлийг хуулийн дагуу зохих ёсоор нь шалгаж шийдвэрлэнэ гэдэгт итгэж чаддаг байх ёстой. иймээс ч хохирогчийн гаргасан гомдлыг аюулгүй, үр дүнтэй хянан шийдвэрлэх тогтолцоог төр, хувийн хэвшил зэрэг бүхий л салбарт бий болгох нь нэн чухал юм. түүнчлэн хохирогчид, даван туулагчдаас мэдээлэл хайж тэдэнд сэтгэл зүйн дарамт учруулахын оронд гэмт этгээдүүдийг олж илрүүлэх, шударгаар нотлох тал дээр илүү нухацтай ажиллаж, дорвитой өөрчлөлт хийх ёстой.

хажууд чинь байгаа аз жаргалтай нэгэн магадгүй сэтгэлийн гүндээ асар том зовлонг тээсээр явааг хэн ч тааж үл мэднэ. биеийн шарх хурдан аних ч сэтгэлийн шарх анихдаа удаан гэдэг. олон цэвэр сэтгэлийг бохирдуулахгүйгээр, зовоохгүйгээр авч үлдэхийн төлөө нийгмээрээ өөрчлөлтийн төлөөх тэмцлээ эхлүүлэх хэрэгтэй. тус охины харуусалт амьдралын түүхийг ахин давтагдахыг үл хүснэ. бэлгийн боловсролтой, сэтгэл зүйн эрүүл монгол иргэн олон байгаасай.